

“АЛТАН ХҮН”-ИЙ БИЧЭЭСИЙГ НЯГТЛАХ НЬ

Ц.БАТТУЛГА

МУИС, ШУС, Ази судлалын тэнхим, e-mail: centreturkicamongol@yahoo.com

ТҮЛХҮҮР ҮГ: Өвгөнтийн булш, Алтан хүн, руни бичиг

ТОВЧ АГУУЛГА: 1983 онд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг, Өвгөнт хэмээх газар хийсэн малтлага судалгаагаар хөмөлдөргө, хударганы гучин есөн алтан чимэг, хүний дүрс, бичиг бүхий алтан ялтас илрүүлжээ. Хүний дүрс бүхий алтан ялтас дээрх бичээсийг эрдэмтэд, Хүннү бичиг, Киргизийн язгууртанд холбогдох руни бичиг гэх зэргээр үзсэн байдаг. Бид энэхүү өгүүлэлдээ “Алтан хүн”-ий бичээсийг нягталсан судалгааны үр дүнг толилуулж байгаа болно.

Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний анги 1983 оны намар Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Их Дулааны салбар Өвгөнт, Үүдэнт хэмээх уулсаас өмнө зүг тэгш талд 9м х 10м голчтой булш малтаж хөмөлдөргө, хударганы гучин есөн алтан чимэг, хүний дүрс, бичиг бүхий алтан ялтас (Наваан, Сумъяабаатар 1987: 5) зэрэг олдвор илрүүлсэн бөгөөд булшийг малтан судалсан археологич доктор Д.Наваан, алтан ялтас дээрх бичээсийг уншиж судалсан доктор Б.Сумъяабаатар нар “Хүннүгийн дурсгал” хэмээн үзэж нэг сэдэвт бүтээл (Наваан, Сумъяабаатар 1987) хэвлүүлсэн ажээ.

Малтан судалсан дээрх булшны олдворын хүний дүрс, бичиг бүхий алтан ялтаснаас бусад нь морины тоног хэрэглэлийн зүйл байгаа нь анхаарал татдаг. Зарим эрдэмтэд олдворын эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан “Хэдийгээр Өвгөнтийн булш тоногдож түүнээс гарсан эд өлгийн зүйлс анхных нь байдлыг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа боловч тэнд оршуулагдсан хүн Уйгурын хаант улс мөхсөний дараа умард Монголыг эзлэн өргөн тархсан

Енисейн Кыргызийн язгууртнуудад холбогдохыг бид бүрэн итгэлтэйгээр баталж байна” (Кляшторный нар 1999: 153) гэж үзсэн ч бий. Тиймээс ч судлаачид уг дурсгалыг нүдээр үзэж судлахыг эрмэлзсээр иржээ.

Бидний хувьд, “Эрдэнэсийн сан”-д хадгалагдаж буй “Алтан хүн”-ийг нүдээр үзэж, судлах боломж 2014 оны 5-р сард тохиосон юм. Дашрамд, шинжлэх ухааны тусын тулд, хүний дүрс, бичиг бүхий алтан ялтасыг үзэж судлах боломж олгосон, “Чингис хаан” дээд сургуулийн захирал, проф. Х.Лхагвасүрэнд гүн талархал илэрхийлье. Тэрбээр ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан байх үедээ, доктор Д.Навааны хамт уг булшийг малтан судалж, олдвор дурсгалыг нэгбүрчлэн бүртгэж, “Эрдэнэсийн сан”-д хадгалуулахад оролцсон археологич гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Хүний дүрс бүхий алтан ялтсан дээрх бичээсийг анх нэрт эрдэмтэн проф. Б.Сумъяабаатар уншиж судалсан билээ. Тэрбээр бичээсийг олон хэл, бичгийн дурсгалуудтай харьцуулан судлаад “Ха’ану

(Ша'ану) тамга” хэмээн унших санал дэвшүүлснээс гадна бичээснээ дурдагдаж буй “тамга” гэдэг нь дардаг тамга биш “тэмдэг” гэсэн утга” (Наваан, Сумъяабаатар 1987: 116-117) -тай болохыг мөн онцлон тэмдэглэжээ.



Зураг 1. Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг, Өвгөнтийн булинаас олдсон хүний дүрс, бичээс бүхий алтан ялтас

Булш хийгээд алтан ялтас дээрх бичээсийн талаар эрс өөр байр суурьтай нэгэн судалгааг нэрт түрэг судлаач С.Г.Кляшторный, Д.Савинов, Д.Шкода нарын эрдэмтэд хэвлүүлсэн (Кляшторный нар 1999: 153) бөгөөд уг судалгааны өгүүллийг археологич доктор Ц.Төрбат монгол хэлнээ орчуулж нийтийн хүртээл болгосон билээ.

Дээрх эрдэмтэд өгүүлэлдээ:

а) *Өвгөнтийн булины археологийн цогц дурсгал нь Сибирь - Төв Азийн эртний Түрэгийн үеийн бусад дурсгалтай нэг хүрээнд байна.*

в) *Алтан брактеат нь Византийн Ираклий ба Леонтий хааны зоосны согд хуулбар бөгөөд Согдын төв нутгийн гадна үйлдэгдсэн байна.*

с) *Брактеат дээрх хүний дүрс ба үрлэн хээн тойргийн хооронд байх тэмдэгтүүд нь хожуу үеийн үсэг зүйн онцлогтой эртний түрэгийн руни бичээс байна. Мөн Өвгөнтийн булины он цаг бүх шинжүүдээрээ МЭ VIII-IX*

зуунд холбогдох бололтой” (Кляшторный нар 1999: 156-157) хэмээн үзсэн байна.

Алтан ялтас дээрх бичээсийн талаар, нэрт түрэг судлаач проф.С.Г.Кляшторный “...Нэгдүгээр мөрөн дэх цорын ганц үг тусгаарлагч нь тэмдэгтүүдийн ялгаа юм. Нармайхсан *t*, саармаг *η*, тагнайхсан *г*. Тиймээс гурван бүлэг тэмдэгтийг зааглаж *таη г* (эхний мөр), *bg* (хоёрдугаар мөр) гэж галиглах нь зүйтэй гээд *таη er beg* гэхэд эхний үгний хоёр утга хоёулаа боломжтой. Энэхүү бичээс нь тодорхой хүний хувь нэр байж болох бөгөөд нөгөө талаар алтан ялтсан дээрх загварчилсан маягтай төдийгүй бодгал шинжтэй уг хүний тодорхой бус зүйрлүүлсэн нэр байж болох юм” (Кляшторный нар 1999: 156-157) гээд бичээсийн эхийг $\text{€} \square \text{Y} \text{H}$ хэмээн сэргээж “*таη er beg*- Тан эр ноён” гэж уншсан бөгөөд хожим С.Г.Кляшторный гуай англи хэлнээ тусгайлан орчуулж гаргасан билээ (Кляшторный 1993: 129-131; Кляшторный 2006 :112-114).

Мөн “...түрэг судлаач С.Харжаубай нэгэн сэтгүүлд алтан ялтас ба бичээсийг хүннүгийн соёл бичиг үсгийн дурсгал гэж тодорхойлсноос гадна хэлийг тодорхойлоогүй, галиг хийгээгүй боловч уг зүйлийг эзэмшигчийн албан тушаалын эрхийг баталгаажуулсан баримт буюу пайз, бичээсийн утга: *Элчийн нэр Амас шат* гэж үзсэн” тухай тэмдэглэжээ (Кляшторный нар 1999: 150).

Бичээсийг одоогоор

- Ха'ану (Ша'ану) тамга гэсэн утгатай

- Тан эр (муж-князь, воин-князь) ноён (*таη er beg*)

- Элчийн нэр Амас шат гэсэн гурван өөрөөр тайлж уншсан судалгаа байна.

Хүний дүрс, бичиг бүхий алтан ялтас, түүний бичээсийг нүдээр үзэж, өмнөх судалгаатай харьцуулахад, “*beg*” –ээс бусад үгийн уншлага ташаарсан болох нь ажиглагдсан билээ. Ташаарсны гол шалтгаан нь бичээсийг баруунаас зүүнш бичсэн гэж үзэж уншсанаас үүдэлтэй. Эртний Түрэг, Уйгурын үеийн зоос, аяганы ёроол зэрэгт

руни бичгээр дугуйруулж бичихдээ нар зөв тойруулж бичдэг тогтсон уламжлалтайг эрхбиш анхаарч, харгалзан үзэх нь зүйтэй болов уу. Тиймээс ч Төв Азийн нүүдэлчдийн бичгийн уламжлал ёсоор, хүний дүрс бүхий алтан ялтас дээр нар зөв тойруулж бичсэн (дэлдсэн) нь тодорхой бөгөөд энэ ч үсэгзүйн онцлог, өгүүлбэрийн байршил зэргээр давхар батлагдаж байна. Өөрөөр хэлбэл, хүний толгойн дүрсний хоёр хажуу талд баруунаас зүүнш нар зөв тойруулж бичсэн руни бичээсийг С.Г.Кляшторный гуай нар буруу буюу зүүнээс баруунш, тодруулбал нэгдүгээр бичээсийн төгсгөлийн үсэг тэмдэгтийг эхний үсэг тэмдэгт, эхний үсэг тэмдэгтийг төгсгөлийн үсэг тэмдэгт гэж үзсэн нь судалгаа ташаарах шалтгаан болжээ.

Бичээсийг нар зөв тойруулж бичсэн гэж үзэх бас нэг үндэслэл нь нэгдүгээр бичээсийн хоёр дахь үсэг тэмдэгт λ (W) бөгөөд Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалуудад тохиолдох тиг хэлбэрээр бичсэнд оршино. Үүний жишээг Уйгурын Хар балгасын нэгдүгээр хөшөө, цаасан дээр бичсэн “Ирк битиг” зэрэг сурвалжийн бичгийн тиг хэлбэр зэргээс тодорхой харж болно. С.Г.Кляшторный гуай ч Уйгурын үеийн буюу VIII- IX зууны бичгийн дурсгалын тиг хэлбэртэй байгааг тэмдэглэсэн байна.

Бичээсийн эхийн сийрүүлэг:

$\delta \lambda \delta$.1

$\epsilon \square$. 2

Үсгийн галиг:

1. BWS \bar{T}
2. Bg

Үсгийн галиг:

1. busat
2. bäg

Үгчилсэн орчуулга:

1. Ариун
2. ноён

Хүний дүрс бүхий алтан ялтас дээрх бичээсийг нэгтгэн үзвэл $\epsilon \square \delta \lambda \delta$ busat bäg буюу Ариун (шударга) ноён гэсэн утгатай ажээ.

$\delta \lambda \delta$ busat

busat нь согд хэлний “ β ws’nty(ариун)” гэх үгээс үүсэлтэй бөгөөд busat баcaγ гэж хоршин тохиолддог болохыг эртний түрэг хэлний толь бичигт (Древнетюркский словарь1969:127) тэмдэглэжээ.

δ (B)

Үгийн эхний, хамгийн их эргэлзээ төрүүлж буй үсэг тэмдэгт мөн болно. Зэрвэс ажихад λ (a) мэт харагдах боловч, нягтлан үзвэл хэвтээ тигээр хурц үзүүр гаргаж дэлдсэн δ (B) тэмдэгт байх магадлал илүү ажээ. Тиймээс бид δ (B) үсэг тэмдэгт гэж үзэв. Харин С.Г.Кляшторный гуай λ (r) үсэг тэмдэгт хэмээн үзсэн байна.

λ (W)

Уг үсэг тэмдэгтийг Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалын тигээр дэлдэж бичсэн байх бөгөөд С.Г.Кляшторный гуай нар буруу буюу зүүнээс баруун тийш уншиж буй тул λ (η) гэж үзсэн байна.

l(s)

Маш тодорхой бичсэн үсэг тэмдэгт. С.Г.Кляшторный гуай хэвлүүлсэн хуулбар эхдээ λ (a) гэж сэргээж уншсан байна. Үүнээс үзэхэд, нэрт эрдэмтэн уг дурсгалыг нүдээр үзээгүй байж болох талтай.

δ (T)

Уг үсэг тэмдэгтийг С.Г.Кляшторный гуай бичээсийн эхний үсэг тэмдэгт гэж үзсэн бол, бид харин бичээсийн төгсгөлийн тэмдэгт хэмээн үзэж байна. δ (T) үсэг тэмдэгт гэдэгт санал нэг байгаа болно.

$\epsilon \square$ bäg

Эртний Түрэг, Уйгурын руни бичгийн дурсгалд хамгийн олон давтамжтай тохиолдох уг үгийг руни бичгийн дурсгалуудад $\epsilon \star$ тиг хэлбэрээр бичих нь түгээмэл бөгөөд \star (b) үсэг тэмдэгтийн \star - λ - \square зэрэг хувилбар буй. Зоосоно дэлдэхэд хамгийн хялбар дөхөмтэй тул энэхүү тэмдэгтийг сонгож авсан байж болох юм.

“Алтан хүн”-ий бичээсийн үсэг тэмдэгтийн тиг хэлбэр зэргээс үзвэл уг дурсгал он цагийн хувьд Уйгурын эхэн үед

холбогдох бололтой. Харин хүний дүрс, бичиг бүхий алтан ялтас нь уг булшны эзэнд зориулж тусгайлан дэлдэж үйлдсэн зүйл байсан уу, эсвээс булшны эзэнд өгсөн дурсгалын зүйл байв уу гэдгийг тогтооход бэрхтэй. Өвгөнтийн булшийг тонох үед бичигтэй зоос золоор үлдэж, бусад алтан зоосууд үрэгдсэн байх магадлалтай, учир нь малтаж судалсан археологчид эрт үед тоногдсон болохыг онцлон тэмдэглэжээ.

Түрэг, Уйгурын язгууртан нар нэгэн үе торгоны замаар, согд худалдаачдаар дамжуулан Визант зэрэг улсад дэлдсэн, өөр өөр зориулалт, агуулга бүхий алт, мөнгөн зоос цуглуулах, бэлэг сэлтэд өгөх, авах нь түгээмэл байсан бололтой. Цуглуулсан алт, мөнгөн зоосны хэмжээгээр уг язгууртны эрх мэдэл, зэрэг зиндаа, хөрөнгө чинээ тодорхойлогддог байсныг үгүйсгэх аргагүй, тиймээс ч язгууртны оршуулгад алт, мөнгөн зоос, ялтас, дуураймал зэргийг дагалдуулдаг байж болох юм. Үүний нэг жишээ нь Булган аймгийн Баяннуур сумын Улаан хэрмийн Шороон Бумбагараас илрүүлсэн алтан зоосууд болно. Уг дурсгалыг малтан шинжилсэн судлаачдын тайлангаас үзвэл “... Нийт 150 гаруй алтан эдлэл илэрч олдov. Тэдгээрийн дотор 40 гаруй нь алтан зоос байв. Уг зоосуудын ихэнхийг дэлдэх аргаар бүтээжээ. Одоо мэдэгдэж байгаагаар, тэдгээрийн нэлээдийг нь Константинополь хотноо дэлдсэн байна. 630 онд дэлдсэн зоос ч

байна. Уг зоосууд нь арилжааны гэхээсээ илүү гоёл чимэглэл, бэлэг дурсгалын зориулалт бүхий аж. Нилээд зоос нь өлгөх, зүүхэд зориулсан сэнжтэйгээс гадна бас зарим нь ямар нэгэн зүйл дээр хадаж, эсвэл утас мэт зүйлээр оёж тогтоож байсан бололтой жижиг нүхнүүдтэй аж. Тэдгээр нүх, сэнж зэрэг нь уг зоосуудын зориулалтыг тодотгох баримт юм. Зоосуудын ихэнх нь дээрээ ямар нэг дүрслэлтэй юм. Тэдгээрийн дотор эртний Визант улсын ихэс язгууртнуудыг дүрсэлсэн зоос хэдэн ширхэг байна. Эндээс олдсон зарим алтан зоосууд нь нимгэн, жин нь бага байна. Энэ нь эрт цагт бас алтан зоосыг дуурайлган хийж, хэрэглэж байсныг харуулж байна” (Очир нар 2013: 223-224) хэмээн тэмдэглэсэн ажээ.

Өвгөнтийн булш болон Шороон Бумбагарын бунхант оршуулгаас илрүүлсэн хүний дүрст алтан зоос, ялтасууд нь дээрх булш, бунхант оршуулга нэгэн цаг үед холбогдох дурсгал болохыг харуулсан баримт уу, аль эсвэл хоёр өөр цаг үед ижил төсөөтэй зоос дагалдуулж оршуулсан оршуулга уу гэдгийг цаашид нягтлан судлууштай.

Торгоны зам хийгээд эртний улсуудын төр, соёлын харилцааг судлахад дээрх алтан зоос, ялтас, дуураймал зэрэг олдворууд эх хэрэглэгдэхүүн болохын хувьд чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэе.

НОМ ЗҮЙ

Древнетюркский словарь, Ленинград, 1969.

Кляшторный С.Г., Савинов Д., Шкода В., 1999. Монголоос олдсон алтан брактеат Төв Азийн гоёл чимэглэлийн урлаг дахь Византийн өгүүлэмж, Орчуулсан Ц.Төрбат, - *Археологийн судлал*, Tom. XIX, fasc. 4, Улаанбаатар

Кляшторный С.Г., 2006. The runic inscription on a golden bractaet from Mongolia, - *Памятники древнетюркской письменности и этнокультурная история центральной Азии*, Санкт-Петербург, 2006.

Наваан Д., Сумъяабаатар Б., 1987. Өвөг Монгол хэл, бичгийн чухаг дурсгал, Улаанбаатар

Очир А., Эрдэнэболд Л., Харжаубай С., Жантегин Х., 2013. Эртний нүүдэлчдийн бунхант булшны малтлага судалгаа, Улаанбаатар.

Klyashtorny S.G., 1993. The runic inscription on a golden bractaet from Mongolia, - *Türk Dilleri Araştırmaları*, Cilt 3, Ankara.

ABSTRACT

TS.BATTULGA

**RECONSIDERING THE RUNIC INSCRIPTION ON THE GOLDEN BRACTAET
FROM MONGOLIA**

In 1983, numbers of artefacts including a breast-strap of harness, thirty nine golden ornaments of crupper and a golden bractaet with an image of a man and a script were found in the process of the excavation of a grave at Ovgont, Buregkhangai soum, Bulgan province. Most researchers agreed that the inscription on the golden bractaet is a Hunnu script or a Runic script related to a Kyrgyz nobleman.

In this article, we present the results of the research on the inscription, and suggest that the inscription on the golden bractaet means “An Honest Nobleman” and the bractaet might be dated to the Uighur period.